



САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР
2025.06.18



ЭРХЭМ ЗОРИЛГО

Иргэдийн эрүүл аюулгүй, тохилог орчинд амьдарч, ажиллах нөхцөлийг дээшлүүлэхэд дүүргийн санхүү, төсвийн оновчтой удирдлага, зохистой харьцааг бүрдүүлэн хэрэгжүүлэх, хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангахад оршино.



ТӨСВИЙН 2025 ОНЫ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 16 дугаар тогтоолоор дүүргийн 2025 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 301.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталж, 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 114,8 тэрбум төгрөг төвлөрөхөөс 110,7 тэрбум төгрөг төвлөрч 89 хувийн биелэлттэй байна. Орлогын гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь задлан авч үзвэл:

- Татварын орлого 110,033.6 сая төгрөг төвлөрөхөөс 112,480.11 сая төгрөг төвлөрч 101 хувиар биелсэн,
- Татварын бус орлого 2,406.6 сая төгрөг төвлөрөхөөс 757.3 сая төгрөг төвлөрч 31.5 хувийн биелэлттэй байна.



ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ 5 САРЫН БАЙДЛААРХ ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/мян.төг/

Д/д	Татварын нэр төрөл	2025 оны 5 сар өссөн дүнгээр		Биелэлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин түүнтэй адилтгах орлого	73,457,938.00	65,230,061.73	-8,227,876.27	89%
2	Үйл ажиллагааны орлого	2,507,304.10	2,242,999.44	(264,304.66)	89%
3	Шууд бус орлого /суутган/	9,296,290.90	15,107,550.91	5,811,260.01	163%
4	Хөрөнгийн орлого /Хадгаламж/	9,242,408.40	9,051,845.73	(190,562.67)	98%
5	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2,109,817.20	2,248,025.44	138,208.24	107%
6	Хөрөнгө борлуулсны орлого	2,287,470.10	1,941,951.60	(345,518.50)	85%
7	Бууны албан татвар	21,636.70	10,268.00	(11,368.70)	47%
8	Улсын тэмдэгтийн хураамж	8,506,694.20	12,382,115.81	3,875,421.61	146%
9	Хог хаягдал үйлчилгээний хураамж	1,200,959.10	791,832.66	(409,126.44)	66%
10	Торгууль, алдангийн орлого	2,299,106.60	736,668.47	(1,562,438.13)	32%
11	Газрын төлбөр	1,403,060.70	982,248.37	(420,812.33)	70%
13	Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	107,484.00	20,574.97	(86,909.03)	19%
14	ОН хөгжлийн сангаас шилжүүлсэн орлого	2,364,684.30		(2,364,684.30)	0%
	НИЙТ ДҮН	114,804,854.30	110,746,143.13	-4,058,711.17	



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ





ОРЛОГЫН НЭР ТӨРЛҮҮД

Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого:

Орлогын төлөвлөгөөг 2,109,817.2 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2,248,025.44 мянган төгрөг төвлөрч 107 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж:

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төрлөөр 1,200.9 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласнаас 791.8 сая төгрөгийн татварын орлого төвлөрүүлж тухайн төрлийн орлогын төлөвлөгөө 65 хувийн гүйцэтгэлтэй байна. Хог хаягдлын гэрээг 1-24-р хороо дээр хийгдэж байгаа тул хяналт тавих боломжгүй хороодын Засаг дарга нарын чиг үүргийн дагуу ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна..



ТӨСВИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 16 дугаар тогтоолоор дүүргийн 2025 оны төсвийн урсгал зардлыг 130.3 тэрбум төгрөг байхаар баталж, 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 99,1 тэрбум төгрөг буюу төвлөрч 76,1 хувийн биелэлттэй байна.

Биелэлтэд нөлөөлсөн хүчин зүйл:

- Хот тохижуулах зардал нь хянагдаж дараа сард гүйцэтгэл гардаг тул нөөлөөлсөн.
- Дүүргийн хөрөнгө оруулалтын зардлууд улирлын шинж чанартай зардал учраас гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гүйцэтгэл хүлээгдэж байна.



ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/2025.05.31-ний өдрийн байдлаар/

/мян.төг/

Д/д	Үзүүлэлт	2025 оны төсөв /Тодотгосноор/	Төлөвлөгөө /2025.05.31/	Гүйцэтгэл /2025.05.31/	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	327,488,770.50	130,249,292.40	99,083,117.60	31,166,174.80	76.1%
2	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,770,838.80	42,401,393.60	27,645,181.00	14,756,212.60	65.2%
2.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,900,195.20	7,153,905.40	6,295,947.90	857,957.50	88.0%
2.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,607,185.30	952,151.80	736,223.00	215,928.80	77.3%
2.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,747,540.80	8,128,792.20	5,636,739.10	2,492,053.10	69.3%
2.4	Хангамж, бараа материалын зардал	12,784,214.90	7,395,495.70	4,618,250.70	2,777,245.00	62.4%
2.5	Нормативт зардал	137,218.30	52,642.50	27,841.90	24,800.60	52.9%
2.6	Эд хогшил, урсгал засварын зардал	7,604,400.20	2,351,354.50	799,385.50	1,551,969.00	34.0%
2.7	Томилолт, зочны зардал	870,000.00	594,800.00	290,743.30	304,056.70	48.9%
2.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,696,674.90	12,256,181.50	6,678,914.70	5,577,266.80	54.5%
2.9	Бараа үйлчилгээний бусад зардал	7,423,409.20	3,516,070.00	2,561,134.90	954,935.10	72.8%
3	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	169,318,295.30	64,317,157.50	63,891,577.40	425,580.10	99.3%
4	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	65,399,636.40	23,530,741.30	7,546,359.20	15,984,382.10	32.1%



ТӨСВИЙН 2025 ОНЫ ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн гүйцэтгэлийн харьцуулалт



Төсвийн эхний 5 сарын байдлаар зардлын төлөвлөгөө 130,249,292.4 мянган төгрөг, гүйцэтгэл 99,083,117.6 мянган төгрөг буюу 76.1 хувьтай байна.



ДҮҮРГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

2025 оны төсвийн жилд ЧД-ийн ИТХ-ын 2024 оны 12-р сарын 26-ны өдрийн 14 дүгээр тогтоол, 2025 оны 05-р сарын 21-ны өдрийн 16 дугаар тогтоолоор дүүргийн 2025 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 43,032,388.8 мянган төгрөг, 2023-2024 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 18,207,388.8 мянган төгрөг, дүүргийн ОНХСангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний зардлын хэмжээг 2,345,994.1 мянган төгрөг, 2024-2025 он дамжин санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 1,813,914.7 мянган төгрөгөөр тус-тус өөрчлөн баталсан.

2025 онд хэрэгжих Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 171 ажлын, 4 ажил хэрэгжиж , 2024-2025 он дамжин хэрэгжих Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 42 ажлын 17 нь хэрэгжиж 50 иргэнд газрын нөхөн олговор 2,119,722.3 мянган төгрөг, 20 ажлын 5,407,232.8 мянган төгрөг, нийт Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 17 ажлын 7,526,955.1 мянган төгрөг олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сан: ОНХСангийн хэрэгжих төсөл арга хэмжээний хувьд хэрэгжүүлэх 2025 оны 8 ажил, 2024-2025 онд хэрэгжүүлэх 9 ажлын хүрээнд 1 ажил хэрэгжиж 19,800.0 мянган төгрөгний санхүүжилт олгосон байна.



САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА.